

БАТЛАВ:
“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....
Төсөл

ТӨМӨР ЗАМААР АЧАА ТЭЭВЭРЛЭХ, ТЭЭВЭРЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

202.. оны ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар Тэг-202../.....

Улаанбаатар хот

Энэхүү Төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г

Нэг талаас "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК, түүнийг итгэмжлэлээр төлөөлж,..... (цаашид "Тээвэрлэгч буюу МТЗ ТӨХК" гэх),

Нөгөө талаас (цаашид “Тээвэрлүүлэгч” гэх)

нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 35 дугаар бүлэг, Төмөр замын тээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, Төмөр замаар ачаа тээвэрлэх журам, Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр (ОАХХ), Вагон эдэлгээний дүрэм (ВЭД), “Монголын төмөр зам” ТӨХК-д мөрдөж байгаа холбогдох бусад дүрэм, журам, заавар, тарифт нийцүүлэн дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь төмөр замын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой Талуудын эрх, үүрэг, хариуцлага, тээврийн хөлс, төлбөр, тооцооны харилцааг зохицуулахад оршино.

1.2. Өртөө, зөрлөгийн салбар замд сэлгээний ажлыг зохих зааврын дагуу хийх ба техник захирамжийн акт, технологийн горим, Техник ашиглалт дүрэм, Дохиолол холбооны журам, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам болон бусад холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдөнө.

1.3. Хэрэв Тээвэрлүүлэгч нь өөрийн эзэмшлийн болон түрээсийн хөдлөх бүрэлдэхүүн (зүтгүүр, ачааны вагон)-ийг “МТЗ ТӨХК”-ийн эзэмшлийн суурь бүтцийг ашиглаж, тээвэрлэлт хийх тохиолдолд энэхүү гэрээ хамаарахгүй.

Хоёр. Тээвэрлэлтийн захиалга, төлбөрийн ерөнхий нөхцөл

2.1 Тээвэрлүүлэгч нь тээвэрлэлтийн сарын төлөвлөгөөнд тусгуулах ачааны захиалга болон захиалгад өөрчлөлт оруулах хүсэлтээ сар эхлэхээс /орон нутгийн харилцаанд 10, олон улсын харилцаанд 15 хоногийн өмнө Тээвэрлэгчид хүргүүлэх бөгөөд Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн хүчин чадал, тээврийн зурмагт нийцүүлэн тээвэрлэх ачааны хэмжээг зөвшилцөнө.

2.2 Ачаа тээвэрлүүлэх захиалгад вагоны төрөл /битүү, хагас, тавцант, цистерн, хоппер г.м/, чингэлгийн төрөл /их, дунд, бага даац, хөргүүртэй г.м/, ачааны нэр төрөл, жин, тоо хэмжээ, сав баглаа, боодлын төрөл, илгээгч, хүлээн авагч, түүний хаяг, харилцааны төрөл зэргийг заавал тусгасан байна.

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

2.3 Тээвэрлэлтийн хөлсийг тарифын дагуу тооцож, тээвэрлүүлэгчид урьдчилан мэдэгдэж, нэхэмжлэл хүргүүлнэ.

2.4 Тээвэрлэлтийн хөлсийг урьдчилан төлсний дараа тээвэрлэгч нь тээвэрлэлтийн хүчин чадал, тээвэрлэлтийн зурмагт нийцүүлэн тээвэрлэлтийн ачааны хэмжээг зөвшилцөн баталгаажуулна.

2.5 Баталгаажсан захиалгыг үндэслэн тээвэрлэлтийн хуваарийг баталж, тээвэрлүүлэгчид хүргүүлэх бөгөөд аливаа нөхцөл байдал улмаас тээвэрлэлтийн хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тохиолдолд тээвэрлүүлэгчид нэн даруй албан бичгээр мэдэгдэнэ.

2.6 Тээвэрлэлтийг хөлсийг урьдчилан төлөөгүй нөхцөлд тээвэрлэлтийн хуваарьт тусгахгүй бөгөөд тээвэрлэлтийг эхлүүлэхгүй.

2.7 Энэхүү гэрээний хугацаанд холбогдох хууль, тогтоомж, тээвэрлэлтийн дүрэм, журам, тогтоосон тээврийн тариф зэрэг эрх зүйн актад өөрчлөлт орсон тохиолдолд тээвэрлүүлэгчид мэдэгдэж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

2.8 Тухайн сард тээвэрлэсэн ачааны тооцоог талууд сарын 15,30-нд 2 удаа тооцоо нийлэх бөгөөд үлдэгдлийг баталгаажуулсан акт үйлдэн гарын үсэг зурж, санхүүгийн тэмдгээр баталгаажуулан төлбөрийг ажлын 3 хоногийн дотор шилжүүлнэ. Аль нэг талаас шалтгаалан санхүүгийн тооцоо нийлээгүй нь төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнг бууруулах, хасах, энэ гэрээнд заасан хариуцлага тооцохгүй байх үндэслэл болохгүй. Хэрэв төлбөр тооцоог төлөөгүй тохиолдолд тээврийг зогсоох хүртэл арга хэмжээ авна.

2.9 Талууд өдөр тутам тээвэрлэсэн ачаа тээврийн тооцоог тээвэрлэсэн ачаа тээврийн бичиг баримтыг үндэслэн хоорондын тооцоог хийнэ.

2.10 Тээвэрлэлтийг баталгаажуулсан боловч тээвэрлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас тээвэр хийгдээгүй, төлбөрийн буцаан олгох нөхцөлд урьдчилан төлсөн нийт төлбөрөөс 30 хувийг суутган авч шилжүүлнэ.

2.11 Төмөр замын ачаа тээврийн хөлс, холбогдох бусад төлбөрийг Тээвэрлэгч ("МТЗ" ТӨХК)-ийн баталсан "Ачаа тээвэрлэлтийн тариф хэрэглэх дүрэм", түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд заасны дагуу тооцож авна.

2.12 Талууд ачаа тээвэрлэлтэд төмөр замын тээвэрлэлт, түүнтэй холбоотой тарифын мөрдлөгийг дагаж мөрдөнө.

2.13 Тээвэрлэгчийн үйлчилгээний үнэ, тарифт тусгагдаагүй тээвэрлэлттэй холбоотой бусад нэмэлт ажил, үйлчилгээ үзүүлсний хөлсийг тухай бүр холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн Тээвэрлэгч тогтооно.

2.14 Тээврийн хөлс, төлбөр, тооцооны үүргээ гүйцэтгээгүйн улмаас Тээвэрлүүлэгчийн ачаа тээвэр саатсан, зогссон тохиолдолд гарах үр дагаврыг Тээвэрлэгч хариуцахгүй.

2.15 Экспортын ачааны захиалга өгөх тохиолдолд Цогтцэций-Зүүнбаян хүртэл тээвэрлэлтийн хөлсийг тээвэрлэгчийн дансанд, Зүүнбаян-БНХАУ хилийн өртөө хүртэл тээвэрлэлтийн хөлсийг "УБТЗ" ХНН-ийн Худалдаа хөгжлийн банкны 499025970 тоот дансанд /РД:5214203 "Монголын төмөр зам" ТӨХК - РД:...../ шилжүүлнэ.

Гурав. Ачааны төрөл, хэмжээ, тээврийн замнал

3.1 "МТЗ" ТӨХК-ийн эзэмшлийн төмөр замын суурь бүтцийг ашиглан тээвэрлэнэ.

3.2 Тээвэрлэх ачаа нь нэр, төрөлтэй хэмжээтэй ачаа байна.

Дөрөв. Гэрээний хугацаа

4.1 Энэхүү гэрээ нь 20... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн 20... оны ... дугаар сарын ...-ний өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр байна.

4.2 Талууд гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан байх ба гэрээг цуцлах, хугацаанаас өмнө дуусгавар болгох, эсхүл гэрээг сунгах асуудлыг 7-10 хоногийн өмнө

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

албан бичгээр мэдэгдэж, харилцан тохирч шийдвэрлэнэ.

4.3 Гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд сунгахаар харилцан тохиролцоогүй нөхцөлд гэрээг дуусгавар болсонд тооцно.

4.4 Гэрээний 4.2 дэх заалтыг мөрдөхөөс өмнө талууд гэрээг дүгнэсэн акт баримт үйлдсэн байна.

Тав. Талуудын нийтлэг эрх, үүрэг

5.1 Ачаа тээвэрлэлтийг төмөр замаар ачаа тээвэрлэх журамд зааснаар гүйцэтгэж, ачилт, буулгалтын ажлыг Ачилт, буулгалтын үед вагоны бүрэн бүтэн байдлыг хангах ерөнхий шаардлага Монгол Улсын стандарт MNS3084:2023-ыг удирдлага болгон гүйцэтгэнэ.

5.2 Вагон жинлэлтийн үйл ажиллагааг 24 цагийн туршид гүйцэтгэж болно.

5.3 Талууд төмөр замын тээвэрлэлт гүйцэтгэх дүрэм, журам, зааврыг баримтлах, гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар гүйцэтгэх, эрх бүхий этгээдээс тавьж байгаа хууль ёсны шаардлагыг зохих ёсоор биелүүлнэ.

5.4 Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, ачаа, тээш, хөдөлгөөний аюулгүй байдал болон ачааны бүрэн бүтэн байдал хохирол учруулах нөхцөл байдлын талаар мэдээлэх, гарах үр дагаврыг арилгахад харилцан туслах үүрэгтэй.

5.5 Хууль, дүрэм, журам, заавар болон гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

5.6 Тээвэрлэгч нь тээврийн хэрэгслийн битүүмжлэл, тэвшний найдвартай байдлыг хангах ба ачааны бүрэн бүтэн байдлыг хангах, хангуулахыг шаардаж ажиллана.

5.7 Тээвэрлэгч тээвэрлүүлэгчийн ачаа тээвэрлэх үйл ажиллагаатай холбогдуулан гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн эрх, үүрэг, хариуцлага хүлээхгүй.

Зургаа. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

6.1 Тээвэрлэгч нь Тээвэрлүүлэгчийн өгсөн захиалгаар ачаатай болон хоосон вагоныг нэр заасан өртөөнд тээвэрлэн хүргэнэ.

6.2 Тээвэрлэгч эзэмшилдээ байгаа вагоны техник ашиглалтын байдал, ачааны бүрэн бүтэн байдал болон хөдөлгөөний аюулгүй байдлыг Төмөр замын тээврийн тухай хуульд заасны дагуу хангах үүрэгтэй.

6.3 Ачааг тээвэрлэлтэд илгээх, хүлээн авах тухай бусад төмөр замын суурь бүтэцтэй байгуулсан ачаа тээврийн гэрээг үндэслэн тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

6.4 Тээвэрлэгч нь ачаа тээвэрлэлт гүйцэтгэх, тухайн хоногийн захиалгын дагуу ачилтад тэнцсэн вагоноор хангах, тэдгээрийг тавьж өгөх, татаж авах сэлгээний ажлыг гүйцэтгэх, ачаатай вагоныг жинлэх зэрэг тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаанд өөрийн зүтгүүрээр үйлчилнэ.

6.5 Вагонд ачигдсан ачаа нь холбогдох техникийн нөхцөлийн дагуу ачигдсан эсэх, ачааны байрлал, овор хэмжээ, нэр төрөл тохирч байгаа эсэх, тээврийн бичиг баримтын бичилт, бүрдэлтийг сайтар шалгаж тээвэрлэлтэд хүлээн авна. Зөрчил, доголдол илэрсэн тохиолдолд ачааг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

6.6 Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн бичиг баримт (дагалдах бичиг) үйлдэгдэж, ачааг хүлээн авсан үеэс ачаа хүлээн авагч этгээд /дараагийн төмөр замын байгууллага/-д хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд ачааны бүрэн бүтэн байдлыг хангана.

6.7 Өмнө ачуулсан ачааг хүлээн авагч авахаас татгалзах, буулгаж авахгүйгээр удаан хугацаагаар зогсоох, дамжин өнгөрөх өртөөдөд Тээвэрлүүлэгч болон хүлээн авагчийн буруугаас вагон саатвал дараагийн ачааг ачихыг зогсоох буюу хязгаарлах эрхтэй.

6.8 Тээвэрлүүлэгч захиалгат ачаагаа тухайн сардаа явуулаагүй, захиалсан ачааны хэмжээнд хүртэл ачилт хийгээгүй, захиалга тасалдуулж вагон сул зогсоосон, тээвэрлэлтийн бэлтгэл ажлыг хангаагүйн улмаас тээвэрлэлт явуулахтай холбоотой гаргасан зардлыг Тээвэрлүүлэгчээс нэхэмжилж, гаргуулан авна.

6.9 Орон нутгийн ачааны харилцааны тээврийн бичиг баримт(дагалдах бичиг)-

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

д хүрэх өртөөний нэр, код, ачааны нэр, жин, байрын тоо, ачаа хүлээн авагчийн шуудангийн тодорхой хаяг, гэрээний дугаар, /харилцах данс, банкны нэр/ утас, телекс, факсын дугаар зэрэг мэдээллийг үнэн зөв тодорхой заасан байна.

6.10 Вагон жинлэлтийн явцад сэлгээ хийх, бусад нэмэлт үйлчилгээ авах тохиолдолд энэ тухай захиалгыг Тээвэрлүүлэгчээс хүлээн авсан даруйд холбогдох ажил, үйлчилгээг шуурхай гүйцэтгэх арга хэмжээ авч ажиллана. Үүнтэй холбогдон гарах зардал, ажил, үйлчилгээний бусад хөлс, төлбөрийг тарифт заасан хэмжээгээр Тээвэрлүүлэгчээс нэхэмжлэн гаргуулан авна.

6.11 Ачааны үлдэгдэлтэй болон бэхэлгээний материалыг салгаж аваагүй, вагон эвдэж гэмтээсэн буюу ачилтын зөрчилтэй вагоныг тухайн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд татаж авахгүй ба санамжийг хаахгүй.

6.12 Тээвэрлүүлэгчээс хүлээн авах ачаанд Техник, болон ачаа тээврийн үзлэгийн явцад галт тэрэгний хөдөлгөөний болон тээвэрлэлтийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх ямар нэгэн гэмтэл илэрвэл тээвэрлэлтэд хүлээн авахгүй байх эрхтэй.

6.13 Энэ гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг Тээвэрлүүлэгчээс шаардах эрхтэй ба биелүүлээгүй тохиолдолд тээвэрлэлтийг зогсоох, гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

6.14 Тээвэрлэгч нь өөрийн хүч хэрэгслээр ачилт, буулгалт хийх болон сэлгээний ажлыг гүйцэтгэх үед хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

6.15 Ачаа тээвэрлэхэд зориулсан вагон ба чингэлэг урьд нь ачсан ачааны үлдэгдэлгүй, бэхэлгээ бүрэн авсан, цэвэрлэгдсэн байна.

6.16 Энэхүү гэрээгээр тохиролцсон хөлс төлбөрийг тогтоосон тарифын дагуу урьдчилан төлөхийг тээвэрлүүлэгчээс шаардах эрхтэй.

6.17 Хууль, дүрэм, журам, заавар, тарифт заасан бусад эрх, үүрэг.

Долоо. Тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг

7.1 Ачилт эсхүл буулгалтын үед вагон болон зүтгүүрт ямар нэгэн эвдрэл, гэмтэл учруулсан тохиолдолд Тээвэрлэгчид нэн даруй мэдэгдэж, акт үйлдэн учруулсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй. Энэ тохиолдолд Тээвэрлүүлэгч дур мэдэн ямар нэгэн засвар, үйлчилгээ хийхийг хатуу хориглоно.

7.2 Өртөөнд хоосон ирсэн вагоныг ачилтад хүлээлгэн өгсөн цагаар санамж нээж тээврийн бичиг баримт үйлдэгдэж гарснаар хаагдах ба энэ хугацааны зам талбайн ашиглалтын төлбөрийг тус санамжийн дагуу төлж барагдуулна.

7.3 Ачигдахаар талбайд буусан ачааны овор хэмжээний стандартын шаардлагыг хатуу баримталж, буулгасан ачааг зам төмрийн гадна талын ирмэгээс 2.5 метрээс багагүй зайд эмх цэгцтэй хураан байрлуулж, найруулагчийн бригад сэлгээний ажил хийх нөхцөлийг хангана.

7.4 Вагоныг гараар болон зориулалтын бус техник, тоног төхөөрөмжөөр сэлгээ хийж хөдөлгөх, төмөр зам дээгүүр автомашин, механизм нэвтрэх, гаргахыг тус тус хориглоно.

7.5 Өртөөний жижүүр нь сэлгээний ажил хийгдэх тухай ачилт, буулгалт хариуцсан талбайн эрх олгогдсон этгээдэд урьдчилан утсаар мэдэгдэх ба ачилт, буулгалтын замын аюулгүй байдлыг хангахын тулд автомашин, өргөх, зөөх механизм, чирэх, ачих, түрэх төхөөрөмжийн үйл ажиллагааг ачилт, буулгалт хариуцан гүйцэтгэж байгаа тал бүрэн зогсоож аюулгүй зайд холдуулсан байна.

7.6 Ачилтын үед шаардлага гарвал дахин сэлгээ хийх, вагон жинлэх нөхцөлд өртөөний жижүүрт мэдэгдэж захиалга өгнө. Ачилт гүйцэтгэхдээ төмөр замын ачилтын техникийн нөхцөлийг хангаж, тогтоосон технологит хугацаанд багтааж, вагоны зохих даацад хүргэх ба нэг гол дээрх ачаалал хэтрүүлэхгүй, вагонд гэмтэл учруулахгүй байх үүрэгтэй.

7.7 Хууль тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцсэн тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй бөгөөд шаардлагыг биелүүлээгүйн улмаас үүдэн гарсан аливаа зардал, хохирлыг бүрэн хариуцна.

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

7.8 Тээвэрлүүлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас өртөө болон салбар зам дээр вагон бусад хөдлөх бүрэлдэхүүнийг эвдэж гэмтээсэн тохиолдолд учруулсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн үнээр тооцож, холбогдох зардлыг нөхөн төлнө.

7.9 Тээвэрлүүлэгч нь ачааг вагоноос үлдэгдэлгүй буулгаж, бэхэлгээний материалыг бүрэн авч вагоныг цэвэрлэн хаалга, хашлага, нээлхий, таг, хүйсийг бүрэн хааж Тээвэрлэгчид хүлээлгэн өгнө.

7.10 Ачилт, буулгалтын талбайн эрх олгогдсон этгээдийн холбогдох утсыг тогтмол ажиллагаатай байлгах ба өөрчлөлт орсон нөхцөлд албан ёсоор Тээвэрлэгчид мэдэгдэх үүрэгтэй.

7.11 Энэ гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг Тээвэрлэгчээс шаардах эрхтэй.

7.12 Өөрийн хүч хэрэгслээр ачилт, буулгалт хийх болон сэлгээний ажлын үед Тээвэрлүүлэгч хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж ажиллана.

7.13 Ачааг хүйтний улиралд тээвэрлэхэд вагонд наалдахаас хамгаалах арга хэмжээ авна.

7.14 Тээвэрлүүлэгч нь ачаатай болохыг дараах баримт бичгээр нотолж, Тээвэрлэгчид ирүүлнэ.

Үүнд:

7.14.1 Бараа, материал, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ;

7.14.2 Бусад төмөр замын суурь бүтэцтэй байгуулсан ачаа тээврийн гэрээ;

7.14.3 Бусад төмөр замын суурь бүтэцтэй байгуулсан өөрийн эзэмшлийн бус вагоныг тээвэрт оролцуулах гэрээ;

7.14.4 Хууль тогтоомж болон тээвэрлэгчээс шаардсан бусад баримт бичиг.

7.15 Хууль, дүрэм, журам, заавар, үнэ, тарифт заасан бусад эрх, үүрэг.

Найм. Тээврийн хөлс, төлбөр, тооцоо

8.1 Тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчийн нэхэмжлэлийн дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн Худалдаа хөгжлийн банкны 404187856 тоот дансанд төлбөрийг урьдчилан шилжүүлнэ.

8.2 Ачааны шинж чанараас хамааруулан харуул хамгаалалттай тээвэрлэгдэх шаардлагатай ачааны даатгал болон харуул хамгаалалтын төлбөр тооцоог тээвэрлүүлэгч тал бүрэн хариуцна.

8.3 Тээвэрлүүлэгчээс Тээвэрлэгчийн дансанд урьдчилан төлсөн төлбөрийн дүнгээс өмнө нь төлөгдөөгүй тээврийн хөлсний үлдэгдэл, түүнд тооцсон алданги, бусад төлбөрийг Тээвэрлэгч суутган авна.

8.4 Гэрээний 7.2-д заасан суутгалыг хийх тохиолдолд Тээвэрлүүлэгчид бичгээр мэдэгдэж, тооцоо, тулгалт хийн дахин баталгаажуулна.

8.5 Тарифын мөрдлөгт НӨАТ тусгагдаагүй тул тээврийн хөлсний төлбөрийг тээвэрлүүлэгчээс НӨАТ-ыг нэмж тооцон гаргуулна.

Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

9.1 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд энэ талаарх саналаа бичгээр ирүүлнэ.

9.2 Нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.3 Нэмэлт өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.

Арав. Талуудын хариуцлага

10.1 Тээврийн хөлс, төлбөр, тооцоо хийгдээгүйгээс ачааг дараагийн тээвэрлэлтэд хүлээлгэн өгч чадаагүй хугацааны вагон, зам талбай ашиглалтын төлбөрийг Тээвэрлүүлэгчээс нэхэмжилж гаргуулна.

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

10.2 Ачааг тээвэрлэлтэд хүлээн авснаас хойш дараагийн суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд Тээвэрлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас үүсэх эрсдэл, хариуцлагыг Тээвэрлэгч хүлээнэ.

10.3 Тээвэрлүүлэгч нь тээврийн хөлсийг гэрээнд заасан хугацаанд бүрэн барагдуулаагүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд 0.5 хувийн алдангийг Тээвэрлэгчид төлнө. Алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50%-аас хэтрэхгүй.

10.4 Ачааг буруу бэхэлж ачсан, тээврийн бичиг баримтыг буруу үйлдсэн, ачааны хаяг тодорхой бус, тээврийн дагалдах бичиг баримтыг дутуу бөглөсөн, зөрүүтэй явуулснаас үүсэх өөрт болон бусдад учирсан хохирол, төлбөр тооцоотой холбоотой хариуцлагыг Тээвэрлүүлэгч хүлээнэ.

10.5 Тээвэрлэгчийн эрх, үүрэгт хамаарахаас бусад тохиолдолд бий болсон эрсдэлийг Тээвэрлүүлэгч хариуцна.

10.6 Тээвэрлэгчийн ачаа болон хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг хангах асуудлыг Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр (ОАХХ), Вагон эдэлгээний дүрэм (ВЭД), Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм болон бусад эрх зүйн актад зааснаар зохицуулна.

10.7 Тээвэрлэлтийн баримт бичигт нэр хаяг буруу бичигдсэн, тээврийн дагалдах бичиг баримтыг зөрүүтэй буюу буруу бүрдүүлсний улмаас гарах зардал, хохирлыг Тээвэрлүүлэгч хариуцна.

10.8 Вагонд ачилт болон буулгалтын үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа тал ачааны болон вагоны бүрэн бүтэн байдлыг хариуцна.

10.9 Тээвэрлүүлэгч нь энэ гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй бол учирсан хохирлыг барагдуулна.

Арван нэг. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл

11.1 "Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл"-д дараах урьдчилан таамаглах боломжгүй үйл явдал, нөхцөл байдал хамрагдана. Үүнд:

11.1.1 Аянга, газар хөдлөлт, үер, шуурга, хуй салхи, цасан шуурга, ой хээрийн түймэр, нийтийг хамарсан гоц халдварт өвчин, тахал;

11.1.2 Монгол Улсад гарсан буюу Монгол Улсыг шууд байдлаар татан оролцуулсан улс төрийн үйл явдал, дайн, зэвсэгт мөргөлдөөн, хориг, бослого, үймээн самуун, иргэний эмх замбараагүй байдал, алан хядах, хорлон сүйтгэх ажиллагаа;

11.1.3 Ажил хаялт, эсвэл эсэргүүцлийн илэрхийлэл болох салбар хамарсан үйл явдал зэрэг байгууллагын өөрийнх нь эсрэг чиглэсэн хөдөлмөрийн асуудалтай холбоотой үйл ажиллагаа.

11.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнээс аль нэг тал үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол энэ тухай нэн даруй нөгөө талд мэдэгдэнэ.

11.3 Ийнхүү онцгой нөхцөл байдал үргэлжлэх хугацаанд мэдэгдсэн тал нь гэрээний үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх эсэх, гарч болох эрсдэл, хохирлыг бууруулах талаар боломжит арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллах, Тээвэрлэгч, Тээвэрлүүлэгч үүссэн асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

11.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

11.5 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас ачаа, өмчлөлийн зүйл устсан, гэмтсэний эрсдэлийг Тээвэрлүүлэгч хариуцах ба ачаа, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах шаардлага гарсан бол энэ тухай Тээвэрлэгчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Арван хоёр. Гэрээг цуцлах

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

12.1 Гэрээний үүргээ зохих журмын дагуу гүйцэтгээгүй, зөрчсөн тохиолдолд Талуудын аль нэг талын санаачилгаар гэрээг цуцалж энэ тухай нөгөө талд мэдэгдэж, үүргийн харилцааг дуусгавар болгоно.

12.2 Гэрээний 12.1-д зааснаас гадна дараах тохиолдолд гэрээг Тээвэрлэгчийн санаачилгаар цуцална. Үүнд:

12.2.1 Тээвэрлүүлэгч өөрийн хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэлт гүйцэтгэх тохиолдолд вагоныг бэлтгэх үүргээ заасан хугацаанд биелүүлээгүй, ачааг хугацаандаа бэлтгээгүй;

12.2.2 Гэрээний 7.3-д заасан хохирлыг бүрэн барагдуулаагүй;

12.2.3 Ачаа тээвэрлэх журам зөрчсөн бусад үйлдэл.

12.3 Энэ зүйлийн 12.2-д зааснаас гадна ачаа тээвэрлэх чиглэлд ачилт хийхийг хязгаарласан, зогсоосон, тээвэрлэлт гүйцэтгэх техник, технологийн бодит боломжгүй болсон, хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн хэрэгцээнд зайлшгүй ашиглах болсон, төрийн байгууллагын шийдвэр, захиалгаар тээвэрлэлт гүйцэтгэх болсон зэргээс шалтгаалан гэрээг цуцалж болно.

Арван гурав. Хавсралт

13.1 Дараах бичиг баримтыг гэрээнд хавсаргах ба эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Гэрээнд хавсаргах хуулбарыг нотариатаар баталгаажуулж болно. Үүнд:

- хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- хэрэв гэрээнд захирлаас өөр этгээд гарын үсэг зурах тохиолдолд түүнд олгосон итгэмжлэл, бүрэн эрхийн нотолгоог хавсаргах;
- тээвэрлэгчийн шаардсан бусад баримт бичиг;
- тээврийн хөлс, тариф /МТЗ гаргаж өгнө/.

13.2 Шаардсан баримт бичгийг өгч чадаагүйгээс үүсэх эрсдэл, гарах зардлыг Тээвэрлүүлэгч өөрөө хариуцна.

Арван дөрөв. Бусад зүйл

14.1 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ мэдээллийг бусдад бичгэн буюу аман хэлбэрээр задруулах, гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглахыг хориглоно. Энэ заалт нь Гүйцэтгэгчийн төлөөлөгч болон туслан гүйцэтгэгч нарт нэгэн адил хамаарна.

14.2 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадаагүй тохиолдолд шүүх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

14.3 Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэх бөгөөд Талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.

14.4 Энэ зүйлийн 14.3-д зааснаас гадна гэрээг Англи, Хятад хэл дээр хөрвүүлж, баталгаажуулж болно.

Арван тав. Мэдээлэл солилцох, харилцах

12.1 Гэрээний хэрэгжилттэй холбоотойгоор бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг Талуудын аль нэг дор дурдсан газар, нэгж, албан тушаалтад дараах албан ёсны хаягаар хүргүүлнэ. Үүнд:

12.1.1 Тээвэрлэгч:

Хаяг: СБД 1-р хороо 13-р хороолол Юнион бюлдинг А блок 7 давхар

Утас: 7000-6622

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

И-мэйл: Info@mtz.mn

Холбогдох газар, нэгж /харьцах/ албан тушаалтан: Тээвэр ложистикийн, төлөвлөлтийн газар

12.1.2 Тээвэрлүүлэгч, гэрээлэгч этгээд:

Хаяг:

Утас:

И-мэйл:

Холбогдох газар, нэгж /харьцах/ албан тушаалтан:

12.2 Энэ гэрээнд заасан хавсралт болон бусад бичиг баримт дутуу тохиолдолд гэрээний бүрдэл хэсэг хангагдаагүй гэж үзэж, гэрээг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэх үндэслэл болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ийн

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
13 дугаар хороолол, Юнион бюлдинг, А
блок, 7 давхар.

Утас:7000-6622

Тээвэрлэгчийг төлөөлж:

Тээвэрлүүлэгчийг төлөөлж:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.